



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2005 оны 10 сарын 07 өдөр

Дугаар 38

Шарга

Г Эх, хүүхдийг эрсдлээс хамгаалах
Сан байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар 10.1.2 дэх заалтуудыг тус тус үндэслэн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. "Эх, хүүхдийг эрсдлээс хамгаалах сан" байгуулах саналыг дэмжин уг сангийн дүрмийг хавсралтаар баталсугай.
2. Дүрмийн хүрээнд санг бүрдүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийгмийн Эрүүл Мэндийн Салбар Зөвлөлийн дарга бөгөөд Сумын Засаг дарга /Д.Түмэнбаяр/-д үүрэг болгосугай.
3. Батлагдсан сангийн дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Л.Сэргсмаа/-д үүрэг болгосугай.



09 028

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2015 оны 10 дугаар сарын 01-ний
38 дугаар тогтоолын Хавсралт

ЭХ, ХҮҮХДИЙГ ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ САНГИЙН ДҮРЭМ

1. Ерөнхий зүйл, хэрэгцээ шаардлага

Сумын хүн ам олон, газарзүйн байрлал харьцангуй алслагдсан, амьдарлын түвшин доогуур, нэн ядуу эмзэг бүлгийн өрх айл олонтой, эхчүүдийн жирэмслэлт, терөлт их байгаа зэрэг нь эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг нэмэгдүүлэх шалтгаан болж 2, 3 дахь шатлалын тусlamж үйлчилгээ авахад хүндрэл учруулж цаг алдсанаас эргэшгүйгээр хүндрэх, улмаар амь эрсдэхэд хүргэж байна.

Иймд "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого"-д заасан эрүүл мэндийн хөгжлийн бодлогын хүрээнд эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний "Эх, хүүхдийг эрсдэлээс хамгаалах сан" байгуулан, сангийн хөрөнгийг дүрмийн дагуу захиран зарцуулах нь дээрх асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг болох юм.

2. Сангийн зорилго

2.1. Эмзэг бүлгийн эх хүүхдэд тавих хяналтыг нэмэгдүүлэх, сум орон нутагтаа судалгаа хийх чадавхийг дээшлүүлэх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний салбар хоорондын уялдаа холбоог өргөжүүлэх, эмчилгээ үйлчилгээний чанарыг сайжруулах.

3. Зорилт

3.1. Хүн амын эрүүл мэндийн байдалд нөлөөлж байгаа хүчин зүйлс, түүнээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг тогтмол цуглуулах, түгээх, ашиглах нөхцлийг бүрдүүлэх замаар эх хүүхдийн эрүүл мэндийн байдлыг сайжруулах, бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх.

3.2. Эмзэг бүлгийн эх, хүүхдэд нөхөн үржихүйн болон эрүүл мэндийн яаралтай тусlamж үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах санхүүжилт, хөрөнгө оруулалт санг байгуулах

3.3. "Нөхөн үржихүйн тусlamж үйлчилгээний загвар" эмнэлэг болох

4. Санг хэрэгжүүлэх үндсэн зарчим.

4.1. Эх, хүүхдийн эрүүл мэндийн бодлого, үйл ажиллагаань нотолгоо, тэргүүн туршлагад тулгуурлана.

4.2. Эх, хүүхдэд эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг үзүүлэхдээ үйлчлүүлэгчийн эрхийг дээдэлнэ.

5. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

5.1. Нэн ядуу өрх, гэр бүлийн жирэмсэн ба хөхүүл эх, 5 хүртэл насын хүүхдийн судалгааг гаргуулж байнгын хяналтанд байлгах

5.2. Хүүхдийн өвчний цогц менежмент болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд мөрдөгдөж байгаа стандарт, оношилгоо эмчилгээний удирдамж, заавар, журмын дагуу эмч, эрүүл мэндийн ажилчдад сургалт зохион байгуулах

5.3. СДЭ-ийн эхийн амрах байрыг байнгын ажиллагаатай болгож эх, хүүхдэд ээлтэй орчин нөхцлийг бүрдүүлж, тохижуулах

5.4. СДЭ-ийн сувилалыг ажилуулж 0-5 насын хүүхдийг хамруулах

5.5. Сумын хэмжээнд эмзэг бүлгийг илрүүлэх судалгаа хийх аргачлалд эмч, мэргэжилтэнг сургах

5.6. Сумын хэмжээнд эмзэг бүлгийн эх хүүхдийн эрүүл мэнд болон өвчлөл эндэгдлийн шалтгаан нөхцлийн судалгааг гаргаж, дүн бүртгэлийн мэдээлэлийн санг бий болгох,

5.7. Эмзэг бүлгийн эх, хүүхдийг 2,3 дахь шатлалын эмнэлэгт илгээх зайлшгүй тохиолдол тулгарсан үед санхүүгийн дэмжлэг үзүүлэх

5.8. Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хэрэглээг нэмэгдүүлэх, хэрэглэх аргыг зорилтот бүлгийн эцэг эхчүүдэд зааж өгөх төлөвлөгөөг гарган ажиллаж уг дэвтрийг хэрэгжүүлж хэвшүүлэх

6. Сангийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

6.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө

6.2. Олон улсын болон түншлэгч байгууллага, төсөл хөтөлбөр, төслийн хөрөнгө, хандив, тусlamж

6.3. Орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж , иргэдийн хандив тусламж

6.4. Нутгийн зөвлөл болон бусад санхүүгийн эх үүсэвр

7. Сангийн хамрагдах хүрээ.

7.1. "Эх хүүхдийг эрсдлээс хамгаалах тусгай сан"-д нэн ядуу амьдаралтай, хүнд нөхцөлд амьдардаг сумаас алслагдсан эмнэлгийн тусламж авахад хүндрэлтэй, дараагийн шатлалын эмнэлэгүүдийн тусламжинд хамрагдах зайлшгүй шаардлагатай нь эмч нарын хамтарсан үзлэг, аймгийн эмнэлэг хяналтын комиссын шийдвэрээр тогтоогдсон эх, хүүхэд хамрагдана.

8. Сангаас олгох дэмжлэгийн хэмжээ.

8.1. Эх, хүүхдийг эрсдлээс хамгаалах сангаас олгох дэмжлэгийн хэмжээг сумын Эрүүл мэндийн салбар зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.

8.2. Санд хамрагдах шаардлагагүй иргэнийг хамруулсан, хуурамч материал бүрдүүлж , зардлыг гаргуулсан тохиолдолд буруутай албан тушаалтанд хариуцлага тооцож гарсан зардлыг эргэн төлүүлэх арга хэмжээ авах.

9. Сангийн удирдлага, зохион байгуулалт.

9.1. "Эх, хүүхдийг эрсдлээс хамгаалах" санг бүрдүүлэх, Сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнг Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах үүргийг сумын Нийгмийн Эрүүл Мэндийн Салбар Зөвлөл хариуцан гүйцэтгэнэ.

9.2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь уг сангийн төсвийг жил бүр батлах бөгөөд хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд хяналт тавин жилд 1 -ээс доошгүй удаа хурлаар хэлэлцэнэ.